

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны Хяналтын Зөвлөлийн ажиллах журам

1. Холбооны хяналтын зовлол (ХЗ) нь вйл ажиллагаандаа Монголын бэлчээрийн менежментийн холбооны дүрэм болон энэхүү журмыг удирдлага болгоно.
2. ХЗ орон тооны бус байна.
3. ХЗ-ийн даргын түр эзгүйд үүрэг гүйцэтгэгчийг хяналтын зовлолийн гишүүдийн хурлын шийдвэрээр томилно.
4. ХЗ дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
 - 4.1. Холбооны санхүүгийн вйл ажиллагаанд хяналт тавих;
 - 4.2. Холбооны вйл ажиллагаа хууль тогтоомж болон холбооны дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянах;
 - 4.3. Холбооны санхүү, нягтлан бодох бүртгэл хотлолт, тайлан, тэнцэл хууль тогтоомжийн дагуу үнэн зов хийгдсэн эсэхийг хянах;
 - 4.4. Холбооны эд хоронгийн хуримтлал, зарцуулалт, Холбооны эд хоронгийн үнэлгээ зов хийгдсэн эсэхэд хяналт тавих;
 - 4.5. Холбоонд ирсэн оргодол, гомдол, саналын шийдвэрлэлтйн байдалд хяналт тавих;
 - 4.6. Холбооны санхүүгийн болон бусад вйл ажиллагаатай холбогдсон зорчлийг арилгуулах арга хэмжээ авах, энэ асуудлаар шүүх болон холбогдох байгууллагад хандах;
 - 4.7. Үйл ажиллагааныхаа тайланг торийн бус байгууллагын тухай хуульд заасан хугацаанд гаргаж огч байгаа эсэхэд хяналт тавих;
 - 4.8. Холбооны их хуралд вйл ажиллагааныхаа тайлан тавих;
 - 4.9. Дүрэмд заасан бусад эрх, үүрэг.
5. Холбооны санхүү, эдийн засгийн вйл ажиллагаанд хийх хяналт шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
6. Холбооны жилийн санхүүгийн тайланд ээлжит хяналт шалгалт хийнэ.
7. Удирдах зовлолийн шийдвэрээр ээлжит бус санхүүгийн хяналт шалгалт хийж болно.
8. ХЗ-ийн хяналт шалгалтанд шаардлагатай бvх баримт бичгийг гаргаж огох, танилцуулах үүргийг холбооны санхүү, ня-бо хүлээнэ.
9. Санхүүгийн шалгалтыг хийхдээ холбооны жилийн орлого, зарлагыг нь дор дурдсан ангиллаар:

- а/ хандивын;
- б/ дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны;
- в/ овлүүлсэн эд хоронго гэсэн чиглэлээр шалгана.

10. Холбоонд 700000-аас дээш тогрогийн хандив буюу овийн хоронго огсон байгууллага, иргэний нэр, зүйлсийн жагсаалтыг гаргуулж авна.

11. Хяналт шалгалтыг хяналтын зовлолийн даргын баталсан удирдамжийн дагуу хийнэ.

12. ХЗ нь хяналт шалгалт хийх болсон тухай шалгуулах этгээдэд урьдчилан мэдэгдэж болно.

13. ХЗ-ийн гишүүн хяналт шалгалтын дүн бүрэн гарахаас олно шалгалтын явцын тухай мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

14. ХЗ нь шалгалтын дүнг зовлолийн хурлаар хэлэлцэн дүгнэлт огч, илэрсэн зорчил дутагдлын шалтгааныг тогтоон, түүнийг арилгах арга хэмжээг авахуулж, шаардлагатай бол зохих хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

15. ХЗ-ийн гишүүдийн олонхи нь оролцсоноор ХЗ-ийн хурал хвчин тоголдор болно.

16. Хуралд оролцогчдын олонхийн саналаар ХЗ-ийн хурлын шийдвэр хвчин тоголдор болно.

17. ХЗ-ийн хурлын тэмдэглэлд:

- хурал хийсэн газар болон цаг,
- хуралд оролцсон гишүүд,
- тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудал,
- баталсан шийдвэр,
- нууц санал хураалтыг тоогоор,
- ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн,
- сонирхлын зорчилтэй холбогдсон тайлбар,
- гарах шийдвэрийн талаар зарчмын оор саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ.

18. ХЗ-ийн хурлаас гарах шийдвэрийн талаар оор саналтай байсан гишүүн тайлбараа бичгээр гаргана.

19. ХЗ-ийн хурлын тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурах богоод тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

20. ХЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хотолсон явдал удирдах зовлолийн хурлаас гаргасан шийдвэрийг хвчингүй болгох үндэслэл болохгүй.

21. Хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж хяналт шалгалт хийсэн зовлолийн гишүүн гарын үсэг зурна.

22. Хяналт шалгалтын дүнг шалгуулсан этгээдэд танилцуулж холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулна. Хэрэв шалгуулсан этгээд хяналт шалгалтын баримт бичигт заасан зүйлийг зовшоороогүй буюу гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбараа

бичиж гарын үсгээ зурна.

23. ХЗ нь сонирхогч этгээдийн овог нэр, хаяг тодорхой бус гомдол, мэдээллийг хвлээж авахгвй.

24. Хяналт шалгалтын явцад гэмт хэргийн шинжтэй зорчил илэрсэн тохиолдолд Хяналтын зөвлөл холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж болно.

25. Хяналт шалгалтын явцад холбооны эд хоронгод хохирол учруулсан нь тогтоогдсон бол уг хохирлыг холбогдох этгээдээр хууль тогтоомжийн дагуу нохон толвүүлэх арга хэмжээ авах саналыг Удирдах зөвлөлд гаргана.

26. ҮЗ уг саналыг хвлээж авч буруутай байгууллага, албан тушаалтнаар хохирлыг саналд заасан хугацаанд нохон толвүүлэх арга хэмжээ авч энэ тухайгаа ХЗ-д бичгээр мэдэгдэнэ.

27. ХЗ хийсэн хяналт шалгалтынхаа дүнгийн тухай мэдээлнэ.

28. ХЗ нь оорийн чиг үүрэгт хамаарах асуудлаар иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулж болно.

29. ХЗ нь мэдээллийн нууцыг чандлан хамгаална.

30. ХЗ-ийн дарга, ХЗ-ийн гишүүдийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг Холбоо хариуцахгвй.